

# International Theatre Institute ITI

## World Organization for the Performing Arts



**Дэлхийн Театрын Өдрийн мэндчилгээ**  
**2026 оны 3–р сарын 27**

**Мэндчилгээг: Уиллем Дефо, АНУ**

Жүжигчин, Театр бүтээгч

Монгол (Орчуулга)

---

### **Дэлхийн Театрын Өдөр 2026 Мэндчилгээ Уиллем Дефо**

Би кино жүжигчин гэдгээрээ танигдсан уран бүтээлч. Гэхдээ миний гүн гүнзгий эх суурийг театр тавьж өгсөн. Би 1977–2003 онд Вүүстер группийн гишүүн болж, Нью-Йорк хотын Перформинг гражид анхны бүтээлүүдээ туурвин тайзнаа тоглож, дэлхийн олон орноор аялан тоглолт хийж байв. Мөн би Ричард Форман, Роберт Уилсон, Ромео Кастелүччи нартай хамтран ажиллаж байсан. Харин одоо Венецийн Биеналлийн Театрт би уран сайхны удирдаачаар ажиллаж байна. Театрын өвөрмөц, эерэг хүч чадал болон түүний чухал ач холбогдолд итгэх итгэлийг минь энэхүү албан тушаал, дэлхий дахинд өрнөж буй үйл явдлууд, мөн театрын уран бүтээлдээ эргэн орох гэсэн чин хүсэл эрмэлзэл минь улам бататгаж өгсөн юм.

Нью-Йоркт байрладаг манай театр компани болох Вүүстер Группд ажиллаж эхэлсэн эхний жилүүд тун даруухан байсан буюу бидний зарим тоглолтыг үзэхээр манай театрт маш бага үзэгчид ирдэг байв. Заримдаа тайзан дээрх уран бүтээлчдийн тоо үзэгчдийн тооноос олон байвал тоглолтыг цуцлах сонголт хийхэд хүрэх үе бидэнд байсан. Гэсэн ч бид хэзээ ч тийм сонголтыг хийж байгаагүй юм. Манай хамт олны ихэнх нь мэргэжлийн театрын уран бүтээлчид биш, өөр өөр салбарын төлөөлөл нэгдсэн байсан тул “тоглолт заавал үргэлжилнэ” гэх уриа бидний гол зарчим байгаагүй. Харин бид үзэгчидтэй заавал уулзах ёстой гэсэн үүргээ үргэлж мэдэрдэг байв.

Бид өдрийн цагаар ихэвчлэн бэлтгэл хийж, орой нь тэрхүү бэлдсэн ажлаа “хийгдэж буй” хэлбэрээр нь үзүүлдэг байлаа. Зарим жүжиг дээр бид хэдэн жилийг зарцуулж, өмнөх бүтээлүүдээрээ аялан тоглолт хийж амьдралаа залгуулдаг байв. Нэг бүтээл дээр олон жил ажиллах нь надад заримдаа уйтгартай санагдаж, бэлтгэл ч нэлээд хүнд тусдаг үе байсан ч эдгээр “хийгдэж буй” тоглолтууд үргэлж догдлом байлаа. Үзэгчдийн тоо цөөн байгаа нь бидний бүтээл тэдэнд сонирхолгүй байна гэх хатуу дүгнэлт мэт санагдах авч энэ бүхэн надад нэг зүйлийг ойлгуулсан нь: Хэдий цөөхөн хүн байсан ч, гэрч болон оролцож буй тэр л үзэгчид театрт утга учир, амь өгдөг юм.

Мөрийтэй тоглоомын танхимд байдаг “ЯЛАХЫН ТУЛД ЗААВАЛ БИЕЧЛЭН ИРЭХ ЁСТОЙ” гэсэн бичиг шиг. Урьдчилан төлөвлөж, найруулж болдог ч бүтээх явц дахь бодит цаг хугацаанд хамтдаа хуваалцан мэдэрсэн бидний туршлага тоглолт бүрд өөр байдаг. Энэ бол театрын

илт давуу тал юм. Нийгэм, улс төрийн утгаар авч үзвэл, өөрсдийгөө болон ертөнцийг ойлгоход бидний хувьд театр хэзээ ч ийм хэрэгцээтэй, амин чухал байгаагүй.

“Өрөөн доторх заан” бол шинэ технологи, нийгмийн сүлжээ агаад энэ нь хүмүүсийг хооронд нь холбодог гэдэг ч, бодит байдал дээр тэднийг улам хуваагдсан, тусгаарлагдсан байдалд оруулж байх шиг санагдана. Би өөрөө нийгмийн сүлжээ ашигладаггүй ч өдөр бүр компьютер хэрэглэдэг, жүжигчнүүдийг хувьд өөрийгөө Google-ээр хайж үзэж ч байсан, мөн мэдээлэл авахын тулд хиймэл оюун ухаантай ч зөвлөлддөг. Гэхдээ хүний бодит харилцаа төхөөрөмжүүдтэй харилцах харилцаагаар солигдох аюул байгааг олж харахгүй байгаа бол та сохор байна гэсэн үг. Зарим технологи бидэнд сайн үйлчилж чаддаг ч, харилцааны тойргийн нөгөө талд хэн байгааг мэдэхгүй байх нь гүн гүнзгий бөгөөд үнэн ба бодит байдлын хямралд оруулж байна. Интернет асуулт тавьж чаддаг ч, театрын бүтээдэг гайхамшиг, бишрэлийг маш ховорхон дамжуулдаг. Театрын гайхамшиг гэдэг нь анхаарал, оролцоо, мөн үйлдэл ба хариу үйлдлийн тойрог дотор хамтдаа байгаа хүмүүсийн зэрэг бүрэлдсэн нэгдэл дээр тулгуурладаг.

Жүжигчин, театрын уран бүтээлчийн хувьд би театрын хүч чадалд итгэдэг, итгэсээр байх болно. Илүү их хагаралтай, хяналттай, хүчирхийлэлтэй мэт санагдах энэ дэлхийд театрын уран бүтээлч бидний өмнө тулгарах сорилт бол театрыг зөвхөн анхаарал сарниулсан зугаа цэнгээнд зориулагдсан арилжааны хэрэгсэл болгох, эсвэл уламжлалыг хуурай байдлаар хадгалагч институци болгон хувиргах явдлаас зайлсхийх явдал юм. Харин театрын жинхэнэ хүчийг хүмүүс, олон нийт, соёл иргэншлүүдийг холбох, мөн хамгийн гол нь бид хаашаа чиглэн явж байгааг тунгаах чадварыг нь дэмжин хөгжүүлэх ёстой.

Агуу театр гэдэг нь бидний хэрхэн бодож байгааг сорьж, юунд тэмүүлэхийг хүсэж байгаагаа төсөөлөхөд уриалдаг юм.

Бид бол нийгмийн амьтад, ертөнцтэй харилцахаар биологийн хувьд бүтээгдсэн оршихуй. Мэдрэхүйн эрхтэн бүр маань учралын үүд хаалга бөгөөд энэ уулзалтаар дамжин бид өөрсдийн хэн болохыг илүү тодорхой ойлгож чаддаг. Түүх өгүүлэхүй, гоо зүй, хэл, хөдөлгөөн, тайз засал гэх мэт нийт урлагийн хэлбэр болох театр нь бидэнд өнгөрснийг, одоог, мөн манай дэлхий ямар байж болохыг харуулж чадна.

*Орчуулсан: Д.Эгшиглэн, ОУ-ын Театрын институтийн Монголын төв*